

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд доор дурдсан агуулга бүхий зүйл, хэсэг, заалт, тайлбар нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.1.7 дахь заалт:

“2.1.7. “суурь тэтгэвэр” гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.20-д заасныг;”

2/2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалт:

“2.1.8.”өндөр насны тэтгэврийн ердийн нас” гэж тухайн даатгуулагчийн төрсөн онд харгалзах өндөр насны тэтгэврийн нас буюу өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх доод насыг.”

3/5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг:

“5.4. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн насны тэтгэвэр тогтоох, эрх үүсэх харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулна.”

4/5 дугаар зүйлийн Тайлбар:

“Энэ хуулийн 5.1.2-т заасан өндөр насны тэтгэврийн нас нь эмэгтэй даатгуулагчийн хувьд 1971 он ба түүнээс өмнө төрсөн даатгуулагчийн хувьд 55 нас, 1972 онд төрсөн даатгуулагчийн хувьд 55 нас 3 сар байна. Цаашид 1973 онд төрсөн даатгуулагчийн хувьд 55 нас 6 сар, 1974 онд төрсөн даатгуулагчийн хувьд 55 нас 9 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1991 онд ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 60 байна.”

“Энэ хуулийн 5.1.3-т заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1976 он ба түүнээс өмнө төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас, 1977 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар байна. Цаашид 1978 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 6 сар, 1979 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 9 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1996 онд ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 55 байна.”

“Энэ хуулийн 5.1.4-т заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1976 он ба түүнээс өмнө төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас, 1981 он ба түүнээс өмнө төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 45 нас, 1977 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар, 1982 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 45 нас 3 сар байна. Цаашид 1978 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 6 сар, 1983 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 45 нас 6 сар байх бөгөөд

тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1984 онд ба түүнээс хойш төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 52, 1989 онд ба түүнээс хойш төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 47 байна.”

“Энэ хуулийн 5.1.5-д заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1971 он ба түүнээс өмнө төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас, 1976 он ба түүнээс өмнө төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас, 1972 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас 3 сар, 1977 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар байна. Цаашид 1973 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас 6 сар, 1978 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 6 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1991 онд ба түүнээс хойш төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 60, 1996 онд ба түүнээс хойш төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 55 байна.”

“Энэ хуулийн 5.1.6-д заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1971 он ба түүнээс өмнө төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас, 1976 он ба түүнээс өмнө төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас, 1972 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас 3 сар, 1977 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар байна. Цаашид 1973 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас 6 сар, 1978 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 6 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1991 онд ба түүнээс хойш төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 60, 1996 онд ба түүнээс хойш төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 55 байна.”

5/6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт:

“6.1.3.хагас хуримтлалын.”

6/8¹ дугаар зүйл:

“8¹ дугаар зүйл.Өндөр насны тэтгэврийн хэмжээг хагас хуримтлалын аргаар бодох

8¹.1. 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн өндөр насны сарын тэтгэврийн хэмжээг бодоход дараах томьёог хэрэглэнэ:

$$T_x = \frac{H_{D_{c2}} + H_{C_{c2}}}{12k}$$

T_x - хагас хуримтлалын тэтгэврийн хэмжээ;

$H_{D_{c2}}$ -нэрийн дансны эцсийн үлдэгдэл;

$H_{C_{c2}}$ -тэтгэврийн даатгалын хуримтлалын эцсийн үлдэгдэл;

K -тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл.

8¹.2.Тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш албан журмаар даатгуулж тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлсөн бол тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

8^{1.3}.Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Үндэсний статистикийн хороо, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл жил бүр тогтооно.

8^{1.4}.Энэ хуулийн 8^{1.2}-т заасан нэмэгдлийг тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар тооцож бодно.”

7/20 дугаар зүйлийн Тайлбар:

Тайлбар: “Энэ хуулийн 20.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан жил нь 2026 онд 5 жил, 2027 онд 6 жил, 2028 онд 7 жил, 2029 онд 8 жил, 2030 онд 9 жил байх бөгөөд 2031 он ба түүнээс хойш 10 жил байна. Мөн хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо 2026 онд даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 5 жилийн нийлбэрийг 60-д, 2027 онд 6 жилийн нийлбэрийг 72-т, 2028 онд 7 жилийн нийлбэрийг 84-т, 2029 онд 8 жилийн нийлбэрийг 96-д, 2030 онд 9 жилийн нийлбэрийг 108-д, 2031 он ба түүнээс хойш 10 жилийн нийлбэрийг 120-д хуваана.”

“Энэ хуулийн 20.2-т заасан жил нь 2026 онд 5 жилээс доош, 2027 онд 6 жилээс доош байх бөгөөд цаашид жил бүр 1 жилээр нэмэгдүүлж, 2031 оноос эхлэн 10 жилээс доош байна.”

8/29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг:

“29.5.2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө тэтгэвэр тогтоолгосон өндөр насны тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг энэ хуулийн 3.3-т заасан суурь тэтгэврийн нэмэгдлийн хэмжээгээр тооцон нэг удаа нэмэгдүүлнэ.”

9/29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэг:

“29.6.Энэ хуулийн 5.4 дэх хэсгийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-ийн тайлбарын “өндөр насны тэтгэврийн” гэсний дараа “ердийн нас” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 13 дугаар зүйл, 17 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйл:

“3 дугаар зүйл.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо

3.1.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо нь доор дурдсан гурван давхаргатай байна:

3.1.1.нэгдүгээр давхарга буюу суурь тэтгэвэр;

3.1.2.хоёрдугаар давхарга буюу тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр;

3.1.3.гуравдугаар давхарга буюу хувийн нэмэлт тэтгэвэр.

3.2.Энэ зүйлийн 3.1.1-д заасан суурь тэтгэврийн зардлын 80 хувийг улсын төсвөөс, 20 хувийг тэтгэврийн даатгалын сангаас, 3.1.2-т заасан тэтгэврийн зардлыг улсын төсвөөс болон нийгмийн даатгалын сангаас тус тус санхүүжүүлнэ.

3.3.Өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн, тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр, шимтгэл төлсөн хугацаанаас хамааруулан тооцсон суурь тэтгэврийн нэмэгдлийг олгоно.

3.4. Суурь тэтгэврийн хэмжээ болон суурь тэтгэврийн нэмэгдлийг тооцох аргачлалыг Засгийн газар батална.

3.5. Суурь тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр авагчийн шимтгэл төлсөн хугацаанаас хамааруулсан суурь тэтгэврийн нэмэгдлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, амьжиргааны доод түвшинтэй уялдуулан Засгийн газар тус тус тогтооно.

3.6.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр дараах төрөлтэй байна:

3.6.1.өндөр насны;

3.6.2.хөдөлмөрийн чадвар алдсаны;

3.6.3.тэжээгчээ алдсаны.”

2/7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг:

“7.1.Даатгуулагчийн өндөр насны сарын тэтгэврийн хэмжээг бодоход дараах томъёог хэрэглэнэ:

$$T_{ц} = Ц_{д} * 0.125\% * Ш_{с}$$

$T_{ц}$ - цалинд үндэслэн тооцсон тэтгэврийн хэмжээ;

$Ц_{д}$ -энэ хуулийн 20.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого;

$Ш_{с}$ -шимтгэл төлсөн сарын тоо.”

3/8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:

“8.2.Тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш тэтгэврийн даатгалын шимтгэлийг албан журмаар төлсөн бол тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.”

4/13 дугаар зүйл:

“13 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээ

13.1.Хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэврийн хэмжээг бодоход дараах томъёог хэрэглэнэ:

$$T_{Бхча} = Ц_{д} * (45\% + (Ш_{241+} * 0.125\%)) * ХЧА\%$$

$T_{Бхча}$ -хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэврийн сарын хэмжээ;

$Ц_{д}$ -энэ хуулийн 20.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого;

Ш₂₄₁₊₋₂₄₁ ба түүнээс дээш шимтгэл төлсөн сарын тоо;
ХЧА%-хөдөлмөрийн чадвар алдалтын хувь.

13.2. Хөдөлмөрийн чадвар алдсаны хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн хэмжээг бодоход дараах томъёог хэрэглэнэ:

$$T_{\text{ХХча}} = C_d * 0.1875\% * Ш_{\text{сар}} * \text{ХЧА}\%$$

T_{ХХча}- хөдөлмөрийн чадвар алдсаны хувь тэнцүүлсэн тэтгэврийн сарын хэмжээ;
C_d-энэ хуулийн 20.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого;
Ш_{сар}-шимтгэл төлсөн сарын тоо;
ХЧА%-хөдөлмөрийн чадвар алдалтын хувь.

13.3.Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан ХЧА%-г бодоходоо даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ нь 70 ба түүнээс дээш хувь бол 100, 50-69 хувь бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тооцно.”

5/17 дугаар зүйл:

“17 дугаар зүйл.Тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээ

17.1.Тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэврийн хэмжээг бодоход дараах томъёог хэрэглэнэ:

$$T_{\text{Бта}} = C_d * (45\% + (Ш_{241+} * 0.125\%)) * \text{ГБГ}_{\text{тоо}}$$

T_{Бта}-тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэврийн сарын хэмжээ;
C_d-энэ хуулийн 20.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого;
Ш₂₄₁₊₋₂₄₁ ба түүнээс дээш шимтгэл төлсөн сарын тоо;
ГБГ_{тоо} - гэр бүлийн гишүүний тоо.

17.2.Тэжээгчээ алдсаны хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн хэмжээг бодоход дараах томъёог хэрэглэнэ:

$$T_{\text{Хта}} = C_d * 0.1875\% * Ш_{\text{сар}} * \text{ГБГ}_{\text{тоо}}$$

T_{Хта}- тэжээгчээ алдсаны хувь тэнцүүлсэн тэтгэврийн сарын хэмжээ;
C_d-энэ хуулийн 20.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого;
Ш_{сар}-шимтгэл төлсөн сарын тоо;
ГБГ_{тоо} - гэр бүлийн гишүүний тоо.

17.3.Энэ хуулийн 17.1, 17.2-т заасан ГБГ_{тоо} нь 1 бол 50, 2 бол 75, 3 ба түүнээс дээш бол 100 хувьтай тэнцүү байна.

17.4.Энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан гэр бүлийн гишүүний хоёр тэжээгч нь нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээг тэдгээрийн авч байсан сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрээс тооцсон сарын дундаж цалин хөлснөөс энэ хуулийн 17.1, 17.2-т заасны дагуу бодож тооцно.

17.5.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан тэжээгч нас барсан бол тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлнэ.”

6/21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг:

“21.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээг тус тус үндэслэн тэтгэврийн төрөл тус бүрээр Засгийн газар тогтооно.”

7/29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг:

“29.2.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.6-д заасан өндөр насны тэтгэврийн насыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ.”

8/29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг:

“29.3.2019 оноос 2023 оны хооронд дараалсан зургаа, долоон жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг түүний хүсэлтэд үндэслэн дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас нэг удаа өөрчлөн бодно.”

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй” гэснийг “60 насанд хүрсэн даатгуулагч” гэж, 5.1.3 дахь заалтын “50” гэснийг “55” гэж, 5.1.4 дэх заалтын “50” гэснийг “52”, “45” гэснийг “47” гэж, 5.1.5 дахь заалтын “55” гэснийг “60”, “50” гэснийг “55” гэж, 5.1.6 дахь заалтын “55” гэснийг “60”, “50” гэснийг “55” гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “6.1.2” гэснийг “6.1.3” гэж, 6.3 дахь хэсгийн “6.1” гэснийг “6.1.1, 6.1.2” гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “5” гэснийг “10” гэж, “60” гэснийг “120” гэж, мөн зүйлийн 20.2 дахь хэсгийн “5” гэснийг “10” гэж, 5.2, 16.1.4, 18.1 дэх хэсгийн “энэ хуулийн 5.1.1-д заасан” гэснийг “өндөр насны тэтгэврийн ердийн” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “Цалинд үндэслэсэн аргаар” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2 дахь заалт, мөн зүйлийн 7.4, 7.5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2 дахь заалт, 21.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.